



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/302

Улиастай

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.18, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 298 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.2.11, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны чиглэл, хаяг, байршлыг өөрчлөж, гэрчилгээг шинээр олгох байгууллагуудыг хавсралтаар баталсугай.


2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс (Л.Лхамсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ч.Дэмчигсүрэн)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТСАЙХАН



d/zahiramj.doc

811296857

Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөлийн үйл ажиллагааг өөрчлөн
гэрчилгээг шинээр олгох байгууллагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн одоогийн байгаа хаяг, байршил	Одоогийн үйл ажиллагааны чиглэл	Хаягийн өөрчлөлт	Үйл ажиллагааны өөрчлөлт
1	Уламжлалт анагаах ухааны төв	Жинст баг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Жинст баг явуугийн гудамж	Уламжлалт анагаах тусламж үйлчилгээ
2	Түдэвтэй сум дундын эмнэлэг		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Анхан шатны тусламж үйлчилгээ
3	Шилүүстэй сум дундын эмнэлэг		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Анхан шатны тусламж үйлчилгээ
4	Сонгино сумын эрүүл мэндийн төв		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Анхан шатны тусламж үйлчилгээ
5	Отгон сумын эрүүл мэндийн төв		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Анхан шатны тусламж үйлчилгээ
6	Ургамал сумын эрүүл мэндийн төв		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ		Анхан шатны тусламж үйлчилгээ